



“ИРГЭДИЙН ИНДЭР-2 НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ”-Т ИРГЭД, ОЛОН НИЙТЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛ ХҮСЭЛТИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ТУСГАЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр




Дархан-Уул аймаг





д/д	Чиглэл	Санал хүсэлтийн товч утга	Хариуцах албан тушаалтан, байгууллага	Хэрэгжилт	Холбогдох зураг
1	Дэд бүтэц	Мангиртын 9 дүгээр хэсэгт картын худагтай болох ажлыг судлах	Б.Батболд Хотын захирагчийн орлогч, Ус суваг ХК	Одоогоор боломжгүй.	
2		Дулааны шугамны нүхэн таглаануудыг газартай чацуу болгох. Машинаар зорчих үед доод талаа цохих тохиолдол гарч байна.	Б.Батболд Хотын захирагчийн орлогч, ДДС ХК	Хүсэлт гаргасан иргэний мэдээллээр 2-р контрын 3 худгийн тагыг багасгасан. Энэхүү ажил цаашид үргэлжлэн хийгдэж байна.	
3		Дархан сумын 11 дүгээр багийн 1 дүгээр байрны “Eggmart” дэлгүүрийн урдах замыг засаад боржурыг нь солихгүй бол болохгүй байгаа бөгөөд 19 дүгээр сургуульруу ороход хүндрэлтэй байна.	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ж.Дорждэрэм “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ	Уг зам нь эвдрэл ихтэй шороон зам байна. Иймд уг замыг автогредирээр замын хэлбэр дүрс гарган тэгшлэж индүүдэж нягтаршуулах шаардлагатай. Манай байгууллагад технологийн техник тоног төхөөрөмж байхгүй учир засварлах боломжгүй.	
4		Усны үнийг үндэслэлтэй нэмсэн эсэх	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ус суваг ХК		
5		Ширээ нурууны айлууд цахилгааны шөнийн тарифд хамрагдах	Б.Батболд Хотын захирагчийн орлогч	Боломжгүй.	

		боломжтой эсэх	Ч.Батжаргал Захирагчийн ажлын алба		
6		Дэвшил хорооллын иргэд шинэ зам тавьсанаас хойш Петровис эсвэл Цагдаагийн газраар тойрч төв рүү ордог, энэ маягаараа 2-3 жил явж байна. Ингэж явахад бензин шатахуунд ч их зардалтай байна. Иймд Петровис ШТС-ын нэг хашлагыг аваад замыг арай дөт болгож болох уу?	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ж.Дорждэрэм “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ	(Олон улсын чанартай авто зам) Зам барилгын норм дүрэмд заасан стандартын шаардлагын дагуу авто машины гарц шинээр гаргах боломжгүй.	
7		Дархан сумын 8 дугаар багийн 11 ба 14 дүгээр байрнуудын, 14 дүгээр багийн 15 дугаар байрны ус гоождог дээврүүдийг судлан оршин суугчдыг мэдээллээр хангах, 10 дугаар багийн 5-4 байранд 2021 онд хийгдсэн дээврийн ажлыг шалгах	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ч.Батжаргал Захирагчийн ажлын алба	Аймгийн Засаг даргын 2021 оны 9 дүгээр сарын 6-ны 01-А/246 тоот захирамжаар батлагдсан ‘ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ ДЭЭВЭР’ төслийн хүрээнд засварын зардлын 30% иргэд, 70%-ийг төрөөс гаргаж хийнэ.	
8		Орон сууцны байрнуудын 1 дүгээр давхарт өргөтгөл хийж болох уу	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ч.Батжаргал Захирагчийн ажлын алба	Боломжгүй.	
9		Тосгонд явган хүний зам тавих	Б.Жавхлан Аймгийн Засаг даргын орлогч П.Батсүх Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлсийн дарга	Байрлал тодорхой биш тул тодруулах шаардлагатай.	
10		Дархан зочид буудлаас	Б.Батболд	Зам засварын ажлын график	




		Оюуны Ирээдүй цогцолбор сургуулийн А байр хүртэлх хагархай замыг засах	Хотын захирагчийн орлогч Ж.Дорждэрэм “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ	төлөвлөгөөний дагуу хийгдэнэ.	
11		5 дугаар брак байрыг дахин төлөвлөлтөд оруулж болох эсэх	Б.Жавхлан Аймгийн Засаг даргын орлогч П.Батсүх Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлсийн дарга	Боломжгүй.	
12		Төмөр замын 9 дүгээр байрны дээврэрт үүссэн мөөгөнцөр, чийг дээр арга хэмжээ авах	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ч.Батжаргал Захирагчийн ажлын алба	Дээвэрт үүссэн мөөгөнцөр, чийгийг оршин суугчид, СӨХ-тойгоо хамтран засвар үйлчилгээ хийхээр төлөвлөсөн.	
13		Хөтөл хорооллын зарим тоггүй газруудад цахилгаан татаж болох эсэх	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ч.Батжаргал Захирагчийн ажлын алба	Одоо буусан байгаа буюу төвлөрсөн айл өрхүүдийн дунд ерөнхий 1 шугам татна. Хол буюу ганц ганцаараа буусан айлуудад цахилгаан татах боломжгүй.	
14		Эко ОО төслийн мэдээллийг нийтэд ил болгох	Б.Жавхлан Аймгийн Засаг даргын орлогч П.Батсүх Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлсийн дарга	Төсөл бэлэн болохоор ил болгоно.	
15		Ногоон зoorьруу өгсдөг авто замын хажууд үерийн далан барихыг судалж, ажил болгох	Б.Жавхлан Аймгийн Засаг даргын орлогч П.Батсүх Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлсийн дарга	2022 оны төсөвт үерийн далан барих ажил суугаагүй, 2023-2024 оны төсөвт суулгана.	
16		Дархан сум доторх явган хүний замын дээрх тэмдэг тэмдэглэгээг	Б.Батболд Хотын захирагчийн орлогч	Зам засварын ажлын график төлөвлөгөөний дагуу хийгдэнэ.	


		хийх, тодруулах	Ж.Дорждэрэм “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ		
17		Дархан сумын дотор автозам дээр хурд сааруулагчийн судалгаа хийж, шаардлагатай газруудад нэмж суурилуулах	Д.Ганзориг Цагдаагийн газрын дарга Ж.Дорждэрэм “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ	Зам засварын ажлын график төлөвлөгөөний дагуу хийгдэнэ. Хурд сааруулагчийн судалгаа хийгдэж 2022 онд сургууль орчмын бүсэд 5 байршилд хурд сааруулагчийг шинээр хийхээр төлөвлөж байна. Үүнд 1. ОИЦ-ын сургуулийн урд зам 2. 15-р сургууль, 3.АШУҮИС- төв замд 4. 2-р хороолол, 5. Цайхун сургууль	
18		Дархан хүнсний уулзвараас доошоо уруудсан зам засварын ажлын мэдээлэл өгөх	Б.Жавхлан Аймгийн Засаг даргын орлогч П.Батсүх Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлсийн дарга	2022 онд зам засварын ажил хийгдэхээр тендер зарлагдсан.	
19		Дархан сум доторх авто зам дээрх тэмдэг тэмдэглэгээг хийх, тодруулах	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ж.Дорждэрэм “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ	Зам засварын ажлын график төлөвлөгөөний дагуу хийгдэнэ.	
20		Дархан сумын 14 дүгээр багийн 10 дугаар байрны хажууд авто зогсоолыг өргөтгөх боломж байгаа эсэх	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ч.Батжаргал Захирагчийн ажлын алба	2022 онд Дархан сумын 16 дугаар баг 10 дугаар байранд авто зогсоох барих ажил төлөвлөгдөөгүй.	
21		Сэлэнгэ явах замын цагаан хаалганы баруун талын 30 айлын цахилгааныг шийдэх боломтой эсэх	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ч.Батжаргал Захирагчийн ажлын алба	Боломжгүй.	
22		31 дүгээр хорооллыг тойрсон асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг хийх	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ч.Батжаргал		




			Захирагчийн ажлын алба		
23	Эрүүл мэнд	Нэгдсэн эмнэлгийн үзлэгийн цаг авах хүнд суртлыг багасгах	Н.Цасчихэр Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Батцэнгэл Эрүүл мэндийн газрын дарга	НЭ-ийн цаг товлолын цахим бүртгэлийн ажилтны тоог хоёроор нэмэгдүүлж үйлчлүүлэгчид цагийг хязгааргүй буюу тухайн сардаа нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлэх цагийг өгөн ажиллаж байна.	 
24		Иргэд эмээ бичүүлэхэд үнэхээр чирэгдэлтэй байгаа ба хүнд суртлыг багасгах талаар ямар шийдэл байгаа вэ.	Н.Цасчихэр Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Батцэнгэл Эрүүл мэндийн газрын дарга	ӨЭМТ-үүд ЭМД-аар хөнгөлөлттэй олгогдож байгаа эмийн ангиллын дагуу А, В бүлгийн эмийг иргэдэд чирэгдэлгүй бичиж байна. Мөн С, Д бүлэгт ангилагдаж буй эмийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, хяналтын бичилтийг үндэслэн ӨЭМТ-ийн эмч иргэдэд чирэгдэл учруулалгүй үйлчилж байна.	
25		Орон нутагтаа MRI аппаратаар зураг авахуулах боломж байна уу? Улаанбаатар хотод 40-с 50 хоногийн дараа үзүүлэх дугаар байна.	Н.Цасчихэр Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Батцэнгэл Эрүүл мэндийн газрын дарга	Нэгдсэн эмнэлэг одоогоор MRI аппаратаар тусламж үйлчилгээ үзүүлээгүй байна. КТГ-н шинжилгээг тодосгогчтой болон тодосгогчгүй гэсэн 2 төрлөөр, мөн ходоод дурандах болон бусад төрлийн өндөр өртөг бүхий	

				шинжилгээг иргэдэд ЭМД-аар үзүүлж байна.	
26		НДШ, ЭМД өндөр төлсөн хэрнээ шүдээ үзүүлж чадахгүй байгаа ба эмнэлэг явахаар цаг дууссан гэх асуудлыг шийдэх. Хэрвээ үнэхээр эмч хүрэлцэхгүй байгаа бол шүдний кабинетээ нэмэх боломжтой эсэх	Н.Цасчихэр Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Батцэнгэл Эрүүл мэндийн газрын дарга	7 хоног бүрийн 4 дэх өдөр ирэх 7 хоногийн шүдний үзлэгийн цагийг (8:15-10:00 цагийн хооронд) утсаар болон цахимаар 1 эмч өдөрт 8 хүнд үйлчлэхээр цаг тараагдаж байна.	 
27		Эрүүл мэндийн 13А маягтыг цахим болгож болох эсэх	Н.Цасчихэр Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Батцэнгэл Эрүүл мэндийн газрын дарга	ӨЭМТ-өөс 13А маягтыг цаасаар болон цахим хэлбэрээр иргэдэд чирэгдэлгүй олгож хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 13Б маягтыг буцаан олгож байхаар шийдвэрлэв. Цахим хэлбэрээр 13А маягтын эрүүл мэндийн байгууллага хооронд илгээх асуудлыг E-Health системээр дамжуулан олгохоор бэлтгэл бэлэн байдлаа хангаж байна.	 
28	Хот тохижилт	Дархан сумын 14 дүгээр багийн 14 дүгээр байрны зоорийн давхарт үйл ажиллагаа явуулдаг	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга З.Эрдэнэбат	Нүүлгэн шилжүүлэх боломжгүй.	



		НААҮГ-ыг нүүлгэн шилжүүлэх боломж байгаа эсэхийг судлах	Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын дарга		
29		СӨХ-дыг болиулж орон сууцны контор байгуулж болох эсэх.	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ч.Батжаргал Захирагчийн ажлын алба	“СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙШИНГИЙН ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТУХАЙ” хуулиар зохицуулагддаг, контор байгуулах боломжгүй.	
30		Дархан сумын 10 дугаар багийн нутаг дэвсгэрийг камержуулах асуудлыг жил бүр санал, хүсэлт тавьдаг энэ жилийн орон нутгийн төсөв дээр байгаа юу	Б.Жавхлан Аймгийн Засаг даргын орлогч П.Батсүх Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлсийн дарга	Цагдаагийн Газраас камержуулалтын төсөл хийгдсэн.	
31		Дархан сумын 11 дүгээр багийн 2 дугаар байрны гаднах тоглоомын талбай эвдэрхий 10 жил болсон бөгөөд засвар хийгдэх эсэх, 8 дугаар багийн 14 дүгээр байрны хүүхдийн тоглоомын талбайны сагсны шийдийг янзлах эсэх, 9 дүгээр багийн 4-6 дугаар байрны гадна хүүхдийн талбайн тохижилт хийгдэх эсэх, 10 дугаар багийн 4-2 дугаар байрны урд хүүхдийн тоглоомын талбай шинээр байгуулах эсэх	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга З.Эрдэнэбат Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын дарга	Жишиг хорооллын засвар төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа. Хуучны тоглоомын талбайн засвар болон шинээр тоглоомын талбай байгуулах ажлууд энэ онд хийгдэхгүй	
32		Дархан сумын 31 дүгээр хороололд олгогдсон газрууд дээрх зарцуулагдсан төсвийг ил болгох. Цаашдын хийгдэх ажлын жагсаалт гаргах	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Д.Батчулуун Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын	Дархан сумын 31 дүгээр хороололд: ➢ 2020.06.18-ны өдрийн аймгийн Засаг даргын 01-А/221 захирамжаар 274 иргэн, ➢ 2020.07.08-ны өдрийн	Дархан сумын 31-р хорооллын газар олголтын байдлыг харуулсан орчны тойм зураг:

			дарга Ус суваг ХК	<p>аймгийн Засаг даргын 01-А/250 захирамжаар 95 иргэн, ➤ 2020.08.28-ны өдрийн аймгийн Засаг даргын 01-А/282 захирамжаар 26 иргэн, ➤ 2020.10.20-ны өдрийн аймгийн Засаг даргын 01-А/330 захирамжаар 18 иргэн,</p> <p>2021.02.22-ны өдрийн аймгийн Засаг даргын 01-А/71 захирамжаар 9 иргэн, нийт 422 иргэний газар эзэмшүүлэх захирамж гарсан. Захирамж гараагүй 5 иргэн байна.</p>	
33	Дархан-50 цогцолборын хогны савуудыг авто зам руугаа ойртуулж тавиад машин зам дээрээсээ хогоо ачдаг болох	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга З.Эрдэнэбат Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын дарга	Дархан-50 цогцолборын зам дагуух байрнуудын хогийн савыг авто замын зорчих хэсэгрүү шахаж байрлуулсан. 2 хогийн сав газар хөлдүү тул дараа шилжүүлэхээр болсон.		
34	“Гангууш” ХХК болон “Экспресс” авто угаалгын хоорондын газар дээр үүссэн хур хогийг аж ахуйн нэгжүүдтэй нь хамтран яаралтай цэвэрлэх	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга З.Эрдэнэбат Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын дарга	Их цэвэрлэгээг хийж, хогийг ачиж зайлуулсан.		
35	Үйлчилгээний төв орчимд орчин үеийн тохижилттой болгож, мод тарьж, хүн суух сандал ширээ тавих боломжтой болов уу?	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга З.Эрдэнэбат Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын дарга	Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын хөрөнгөд бүртгэлтэй явган зам дагасан 24 ширхэг сандал, 24 ширхэг хогийн сав байгаа. Мод, бут, зүлэг бүхий ногоон байгууламжтай.		


36		10 дугаар багийн 26 дугаар цэцэрлэгийн ойр орчимд үүссэн хог, 8 дугаар багт шинээр баригдсан 5 давхар саарал байшингийн хажууд үүссэн хог, Микрийн айлуудын доор байдаг том хонгилуудад үүссэн хог, 7 дугаар багт үүссэн хог, Хүүхдийн парк дотор үүссэн хог, 8 дугаар багт үүссэн хогнуудыг яаралтай цэвэрлэх	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга З.Эрдэнэбат Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын дарга	8-р багт үүссэн хог, саарал байшингийн орчмын хогийг татан зайлуулсан.	
37		5 дугаар багийн 20-4 дүгээр байранд үүссэн орцны хаалгануудтай холбоотой маргааныг СӨХ-той нь холбогдон шийдвэрлэх	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга Ч.Батжаргал Захирагчийн ажлын алба	20.4 дүгээр байрны 1 дүгээр орцонд амьдардаг гомдол гаргасан иргэнд чип өгсөн. /Дөл СӨХ Наранбямба 99376506/	
38		16 дугаар багийн 10 дугаар байрны хажууд хогийн цэгтэй болгох	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга З.Эрдэнэбат Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын дарга	Хогийн савыг худалдан авах ажлын судалгааг хийсэн.	
39		Дархан сумын 2 дугаар багт хогны машин тогтмол хуваарийн дагуу явуулах	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга З.Эрдэнэбат Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын дарга	Хуваарийн дагуу явж байгаа.	
40		380 айлын орон сууцанд гадна, дотно засвар хийх боломжтой эсэх	Б.Жавхлан Аймгийн Засаг даргын орлогч П.Батсүх Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлсийн	Боломжгүй. Өмнөх дээвэр засварын ажил Шүүхийн маргаантай байгаа.	


			дарга		
41		Дархан сумын нутаг дэвсгэр дээрх бүх гэр хорооллын гаднах гэрэлтүүлэг хэзээ хийгдэж дуусах вэ?	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга З.Эрдэнэбат Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын дарга	Одоо байгаа гэрэлтүүлгүүд бүгд хэвийн ажиллаж байгаа.	
42		Дархан буудлын машин зам дагуу гэрэл байрлуулах ил байгаа арматурын хогийг цэгцлэх	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ч.Батжаргал Захирагчийн ажлын алба	Авто зам дагуу гэрэлтүүлгийн ажил эхлэх хүртэл гэрлийн шонгийн сууринд түр хамгаалалт хийсэн.	
43		11 дүгээр багийн 11 дүгээр байрны 3 ба 4 дүгээр орцны хонгилоос үнэр гаргаж байгаа бохирын хоолойнуудыг шалгах	Б.Батболд Хотын захирагчийн орлогч, Ус суваг ХК	11 дүгээр багийн 6 дугаар хорооллын 11 дүгээр байрны 1 дүгээр орцны зоорийн давхараас өмхий үнэр үнэртээд байна гэсэн иргэний гомдлын дагуу 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр “Дархан ус суваг” ХК-д дуудлага өгч бөглөөг гаргасан.	 
44		Мангиртад айлуудын дунд байдаг хуванцар сав хайлуулдаг үйлдвэр орчноо бохирдуулж байгаа эсэх дээр хяналт тавих	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга Ч.Батжаргал Захирагчийн ажлын алба	Хуварцарын үйлдвэр ажиллахгүй байгаа. Хажуу талын айл хог шатааж байгааг мэдэгдэж анхааруулга сэрэмжлүүлэг өгсөн.	

45	Төмөр замын 14 дүгээр багийн СӨХ, 11 дүгээр багийн 12 дугаар байрны СӨХ, 11 дүгээр багийн 18 дугаар байрны СӨХ, Микрийн 14 дүгээр байрны СӨХ-дуудын үйл ажиллагааг сайжруулж өгнө үү	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ч.Батжаргал Захирагчийн ажлын алба	Дархан сумын ЗДТГ-аас СӨХ-дын бүтэц, бүрэлдэхүүнийг өөрчлөхөөр ажиллаж байна.	
46	Тосгоны автобусны буудлуудын тоог яаралтай гаргаж, тохижилт үйлчилгээ хийн, гэрэлтүүлэх	Б.Жавхлан Аймгийн Засаг даргын орлогч П.Батсүх Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлсийн дарга	Буудлын тохижилт хийх ажилд гүйцэтгэгч байгууллагаас үнийн санал авч байна.	
47	Нохой, муурны устгал үргэлжлүүлэн хийгдэх үү	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ч.Батжаргал Захирагчийн ажлын алба	Нохой устгалын ажил явагдаж дууссан. Муур устгалын ажил үргэлжилж байгаа.	
48	Оюуны Ирээдүй цогцолбор сургуулиас 23 ба 25 дугаар хороолол орох замд гэрэлтүүлэг хэзээ хийх вэ?	Б.Жавхлан Аймгийн Засаг даргын орлогч П.Батсүх Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлсийн дарга	Гэрэлтүүлгийн ажил 2022 онд хийгдэнэ.	
49	Дархан сумын сул шороон дээр зүлэгний үр цацаж эко хорооллууд бий болгох	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга З.Эрдэнэбат Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын дарга	“Ногоон Дархан” хөтөлбөрийн хүрээнд 2022 онд төлөвлөгдсөн ажлууд хийгдэнэ.	
50	Тосгонруу явдаг 18-ын буудал хогийн цэг болсон ба ТҮЦ-ийн араар жолооч нар тамхины хогоо хаяж, ил задгай шээж байна. Арга	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга З.Эрдэнэбат Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын	Жолооч нарт анхааруулж мэдэгдсэн. Асуудлыг шийдвэрлэхээр багийн даргатай холбогдож Түцний эзнийг хайж байгаа.	

		хэмжээ яаралтай авах	дарга		
51	Газрын Харилцаа	Өнгөрсөн хугацаанд төрийн бус байгууллагын нэрээр олон хүний төлөөлөл гэж газар авсан тохиолдолууд байдаг. Тэр зарчмаар олгогдсон, ашиглаагүй газруудыг ил болгох	Б.Жавхлан Аймгийн Засаг даргын орлогч Д.Батчулуун Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга	<p>➢ 2015 оны аймгийн Засаг даргын 02 дугаар захирамжаар Хөрөнгө оруулалт хөгжлийн төв НҮТББ-д цэцэрлэгийн зориулалттай газрыг 2 жилийн хугацаатай олгосон. 2015 оны аймгийн Засаг даргын А/270 дугаар захирамжаар газар эзэмших зориулалтыг цэцэрлэг, орон сууц болгож өөрчилж 2 жилээр сунгасан. 2016 оны аймгийн Засаг даргын А/266 дугаар захирамжаар байршил, зориулалтыг өөрчилж амины орон сууцны зориулалтаар 5000 м.кв газрыг 20 жилийн хугацаатай эзэмшүүлсэн.</p> <p>Дээрх аж ахуй нэгжээс өөр төрийн бус байгууллагад газар эзэмшүүлээгүй болно.</p>	<p>ХОХТ НҮТББ-д олгосон газрын тойм зураг:</p> 
52		Иргэд 0.7 га газраа яаж өмчилж авах вэ?	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Д.Батчулуун Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга	<p>2003-2015 он хүртэл 0,07 газрыг жил бүрийн ГЗБ төлөвлөгөөнд тусган газар олгох үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж ирсэн. Дархан сумд бүртгэлтэй иргэд маань 0,07 га газраа авч чадаагүй бол www.Egazar.gov.mn цахим хуудас болон Дархан сумын газрын даамлаас газар өмчилж аваагүй лавлагааг аваад бусад орон нутгаас газраа авах боломжтой.</p>	<p>Дархан сумын хэмжээнд 2022 онд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх буюу хуучин суурьшлын бүс дэх өмчлүүлэх газрын төлөвлөлтийн тойм зураг /шинээр 0,07 га гэр бүлийн хэрэгцээнд өмчлүүлэх газар төлөвлөгдөөгүй болно/:</p> 

					
53		Хонгор суманд Атар эзэмших аян нэрийдлээр 2021 оны наадмаар ухсан газрын мэдээллийг нийтэд ил болгох	Д.Батчулуун Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Т.Атархишиг Хонгор сумын Засаг дарга	Сумын Засаг даргын 2015 оны 150 дугаар шийдвэрээр иргэн Д.Ганхуягт ХАА-н цогцолборын зориулалтаар 3 га газрыг 2 жилийн хугацаатай тус сумын 1 дүгээр баг төмсний бригад орчимд эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн. 2018 оны 226 дугаар шийдвэрээр Д.Ганхуяг нь иргэн Г.Чойжилд газар эзэмших эрхийг шилжүүлсэн. Дээрх газрыг сунгаж атар газар хагалсан байна. Иргэдээс ирсэн өргөдөл гомдлын дагуу сумаас ажлын хэсэг гарч үйл ажиллагааг зогсоосон.	Хонгор сумын 1-р баг төмсний бригад орчимд Д.Ганхуягын эзэмшиж буй газрын тойм зураг: 
54	Байгаль Орчин	Ойн санг хааж байгааг дэмжиж байна. Ойн цэвэрлэгээний асуудлын талаар ойн нөхөрлөлүүдтэй зөвшилцөж болохгүй юу? Учир нь ойн түймрийн асуудлыг нөхөрлөлүүд хариуцдаг.	Б.Жавхлан Аймгийн Засаг даргын орлогч Г.Батбаяр Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	2022.03.26-ны өдөр Ажлын хэсэг Хонгор сумын Хүрэн манжинт гэх газар арчилгааны зориулалтаар мод бэлтгэсэн талбайтай танилцсан. Бусад мод бэлтгэлийн талбайтай ажлын хэсэг танилцсаны дараа чиглэл өгч ажиллахаар боллоо.	
55		Шарын гол сумын усны эхэн дээр байгаа алтны уурхайнуудыг цэгцэлж өгнө үү? Бууртын худаг, Буянтын худаг дээр байгаа алтны уурхайнууд цэвэр усны нөөцөөс хомсолж байгааг тодруулах	Б.Жавхлан Аймгийн Засаг даргын орлогч Г.Батбаяр Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Ганзориг Цагдаагийн газрын	Нээлттэй хэлэлцүүлгээр Шарын гол сумын усны эхэн дээр буюу Бууртын худаг, Буянтын худагт үйл ажиллагаа явуулж алтны уурхайнуудын асуудлыг хэлэлцэнэ.	

			дарга Б.Лхамсүрэн Шарын Гол сумын Засаг дарга		
56		Дархан-Уул аймагт үйл ажиллагаа эрхэлдэг уул уурхайн компаниудтай, иргэдийн төлөөллийг оролцуулан нээлттэй хэлэлцүүлэг хийх.	Б.Жавхлан Аймгийн Засаг даргын орлогч Г.Батбаяр Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Дархан-Уул аймагт үйл ажиллагаа эрхэлдэг уул уурхайн компаниудтай, иргэдийн төлөөллийг оролцуулан нээлттэй хэлэлцүүлгийг 2022.04.15-ны өдөр хийхээр төлөвлөсөн.	
57	Мэдээлэл, харилцаа холбоо	“Иргэдийн Индэр” нээлттэй хэлэлцүүлгийн зарыг хуучин Дарханы Хаан банктай дэлгэц, Залуучууд театрын том дэлгэцээр хойшид нийтэд түгээх	О.Хүрэлчулуун АЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Соёл-Эрдэнэ Мэдээлэл, технологийн албаны дарга		
58		Иргэд хашаандаа тахиа тэжээж болохуу	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ч.Батжаргал Захирагчийн ажлын алба	Боломжгүй.	
59	Нийгмийн харилцааны асуудал	Захын урд талын нүхэн гарцыг камержуулах	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга З.Эрдэнэбат Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын дарга	Дархан сумын мэргэжилтэнгүүдтэй холбогдож камер суурилуулахаар ярилцаж байна.	
60		Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд байгаа хөл бөмбөгийн талбайг олон нийтэд нээлттэй болгож болох эсэх	Н.Цасчихэр Нийгмийн бодлогын хэлтсийн дарга А.Амараа Биөийн тамир спортын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	Хөл бөмбөгийн талбайн ажил санхүүжилт шийдэгдээгүйн улмаас бүрэн дуусаагүй. Гүйцэтгэл 90 хувьтай байна..	

61		Ногоочдын тарьдаг ногоонд ямар хяналт тавьдаг вэ, намар нь нэгдсэн журмаар дээж авч шалгадаг эсэх	Д.Бат-Эрдэнэ Мэргэжлийн хяналтын газрын дарга	МХЕГ-аас ирүүлсэн удирдамжаар урьдчилан сэргийлэх болон хяналт шинжилгээтэй шалгалт хийгддэг. 2021 онд 14 ААНБ, 27 иргэний төмс хүнсий ногооны 109 дээжинд шинжилгээ хийсэн. Шаардлага хангаагүй сорьц илрээгүй.	
62		Хөтөл хорооллын халуун усны газрыг цагийн хуваарийн дагуу байнгын ажиллуулах	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга	Хэвийн ажиллаж байгаа болно.	
63		Дархан сум доторх такси үйлчилгээний жолооч нарыг Дархан-Уул аймгийн Автотээврийн төв харьяандаа авч болох эсэх	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Б.Батсайхан Авто тээврийн төвийн дарга	Тус төв нь хот доторх болон сум хоорондох такси үйлчилгээг харьяандаа авахаар ажиллаж байна.	
64	Боловсрол	БШУГ-ын ёс зүйн хороо ямар үйл ажиллагаа явуулдаг газар вэ?	Н.Цасчихэр Нийгмийн бодлогын хэлтсийн дарга С.Галбадрах БШУГ-ын дарга	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 05 сарын 01-ний өдрийн А/243 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм”-ийг, 2 дугаар хавсралтаар “Ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам”-ыг баталсан. Энэ журмын дагуу аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 01-А/13 дугаар захирамжаар “Ёс зүйн зөвлөл”-ий байгуулсан. Ёс зүйн зөвлөл нь “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн	

				боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм"-ийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчил гаргасан талаарх асуудлыг шалгаж, хариуцлага хүлээлгэх үндэстэй эсэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байгууллага юм.	
65		Дархан-Уул аймгийн эрчүүдийн төлөө сургалт хийх нөхцөлөөр хангах	О.Хүрэлчулуун АЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Цасчихэр Нийгмийн бодлогын хэлтсийн дарга		

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС